



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

Өрийг хувьцаагаар солих зорилгоор
хаалттай хүрээнд нэмж гаргаж буй
энгийн хувьцааг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 5.1, 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шарын гол” ХК-ийн өрийг хувьцаагаар солих зорилгоор хаалттай хүрээнд нэмж гаргаж буй 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 2,253,583 /хоёр сая хоёр зуун тавин гурван мянга таван зуун наян гурав/ ширхэг энгийн хувьцааг бүртгэн, тус компанийн нийт гаргасан хувьцааг 12,423,825 /арван хоёр сая дөрвөн зуун хорин гурван мянга найман зуун хорин тав/ ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /Б.Дөлгөөн/-т үүрэг болгож, нэмж гаргаж буй энгийн хувьцааг үнэт цаас гаргагчийн тодорхойлсон хувьцаа эзэмшигчийн өмчлөлд бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсантай холбогдуулан үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж ажиллахыг “Шарын гол” ХК /Х.Уянга/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН